

АУДИТЫН ТАЙЛАН

**ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВ
2015 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР
ДУУСГАВАР БОЛГОСОН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

ТАБ-ын тэргүүлэх аудитор: С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг: enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: Ц.Ойдов
Утас: 261585
Цахим хаяг: oidovts@audit.gov.mn

Шинжээч: Н.Нямдаваа
Утас: 260512
Цахим хаяг: nyamdavaan@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: Монгол Улсын Үндэсний аудитын газар
Засгийн газрын IV байр, Бага тойруу-6,
Улаанбаатар-46, Монгол улс
Вэб сайт: www.audit.mn



MAGIC
CONSULTING AUDIT

“МЭЖИК КОНСАЛТИНГ АУДИТ” ХХК

Гүйцэтгэх захирал: С.Мөнхбаяр
Утас: 88106070
Цахим хаяг: info@magicgroup.mn

Ахлах аудитор: Н.Мөнхзаяа
Утас: 99100691
Цахим хаяг: munkhzaya.n@magicgroup.mn

Аудитор: А.Одонтулгалаг
Утас: 88113225
Цахим хаяг: audit@magicgroup.mn

Хаяг: УБ хот БГД 17-р хороо
Ард-Аюушийн гудамж Дизайнер
Төвийн 1-р давхар

“ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ”-ИЙН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл	3
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин	3
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа	4
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн	4
5. Материаллаг байдлын түвшин	5
6. Дотоод хяналт	5
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар	5
8. Шилэн дансны мэдээлэл	5
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар	6
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар	6
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:	6
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:	7
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	7
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	7
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	7
17. Зөвлөмж	7
18. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт	8



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ
Н.ЦОГБАДРАХ ТАНАА

2016.02.25 № 3/316
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн болно.

Зөрчилгүй санал дүгнэлт

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЭНХЗАЯА

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2016\0225SAG89.Docx

УХА0122

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 дэхь заалт, Монгол улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Монгол улсын Ерөнхий Аудиторын 2013 оны 158 дугаар тушаалаар батлагдсан журмын 2.7, Монгол улсын Ерөнхий Аудиторын 2014 оны 298 тоот тушаалын дагуу 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /УАГ-САГ/2015/37/СТА-ГАК-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2015 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төвийн захирал санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2015 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 01 дүгээр сарын 25-наас 2015 оны 2 дугаар сарын 24 –ны хооронд хийхээр төлөвлөн Мэжик консалтинг аудит ХХК-ийн багийн аудитор хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Мэжик консалтинг аудит ХХК аудитыг 2016 оны 01 дүгээр сарын 25-наас 2016 оны 2 дугаар сарын 24-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайлангийн төслийг 2016 оны 2 дугаар сарын 25-нд Үндэсний аудитын газарт хүргүүлж, баталгаажсан дүгнэлт тайланг Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн төсвийн захирагч нь Монгол улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Компанийн тухай” хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Тус байгууллага “Байгалийн голомтот, зоонозын өвчнийг тандах, хянах, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг судалгаа, нотолгоонд тулгуурлан мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулж, халдварын эрсдэлийг багасган, хүн амын өвчлөл эндэгдлийг бууруулахад оршино.” эрхэм зорилгоо биелүүлэхээр стратегийн зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “агентлагын дарга тус агентлагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн захирагч Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн төсвийн 2015 оны төсвийг Сангийн яамны төрийн сангаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудитыг гүйцэтгэхдээ Улсын секторын Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар”, шилэн дансны тухай хууль, бусад холбогдох заавар журмуудыг шалгуур болгож, Монгол Улсын Ерөнхий аудиторовн тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”, ҮАГ-ын санхүүгийн тайлангийн аудитын гарын авлагын арга зүйг ашиглав.

Аудитаар Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн төсвийн 2015 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 13-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна. Улсын секторын Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар”, бусад холбогдох заавар журмуудтай нягтлан бодох бүртгэлийн програм нь нийцсэн байна.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Материаллаг байдлын түвшин:

2015.12.31-нээр дуусгавар болсон санхүүгийн тайланд тусгагдсан тоон үзүүлэлтүүдээр аудитын рисков хэмжээ болон материаллагийн түвшинд нөлөөлөх хүчин зүйлсийн нөлөөллийг урьдчилан үнэлж, нийт зардлын төлөвлөгөө 2,056,749.9 мянган төгрөгийг материаллаг байдлын суурь болгон түүний 1 %-иар тооцож материаллаг байдлын хэмжээг 20,567.5 мянган төгрөг гэж урьдчилан тогтоов. Гүйцэтгэлээр материаллаг байдлыг дахин хянаж үзэхэд өөрчлөлт орсонгүй.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2015 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу салбарын яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Сангийн сайдын тушаалаар батлагдсан төсвийн сар, улирлын хуваариар 1,640,146.3 мянган төгрөг батлагдсанаас 2015 оны 11 сарын 09 ний төсвийн тодотголоор 1,624,346.3 мянган төгрөг болж буурсан байна. Энэ нь Засгийн газрын 2014 оны 5 сарын 10 ны өдрийн 147 тоот тогтоолын дагуу төсвийг хэмнэлтийн горимд оруулан 2015 оны 12 сарын 31 ний байдлаар Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн төсвийн захирагч нь 2015 онд улсын төсвөөс урсгал зардалд 1,642,885.9 мянган төгрөгийн санхүүжилт авчээ.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 8.3. "Төрийн аудитын байгууллага нь өөрийн санаачилгаар шилэн дансны мэдээлэлд аудит хийж болно" гэсэн заалтын дагуу тус байгууллагын шилэн дансны мэдээллийг шалгахад төсөв болон санхүү, сарын төсвийн гүйцэтгэл, төсвийн 2015 оны сар, улирлын хуваарь, Хүний нөөц, холбоо барих, гэсэн хэсгүүдээр нээлттэй байлгаж вебсайт хуудсандаа байршуулсан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 25 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 28 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаврыг тодорхойлж чадвал:

Нийгмийн даатгалын сангаас олгосон ХЧТАТэтгэмж 20,302.5 мянган төгрөгийг ерөнхий журналд цалингийн өглөгийг өсгөж, НД-н сангаас авах авлагаар тусгасан боловч, Мөнгөн гүйлгээний тайланд орлого, зарцуулалтаар бүртгэж тайлагнаагүй байна.

Төслийн ажилчдын цалин 13,124.0 мянган төгрөг, Багшийн цалин 1,240.2 мянган төгрөг, нийт 14,364.2 мянган төгрөгийн цалингаас НДШ ногдуулаагүй байна.

Эдгээр зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, хамааралтай байх, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн төсвийн 2015 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, орлого, төсвийн зарцуулалтын дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 100 хувь, мөнгөн хөрөнгийн 100 хувь, нийт зардлын 56 хувь, нийт хөрөнгийн 79 хувийг тус тус эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Нийгмийн даатгалын сангаас олгосон ХЧТАТэтгэмж 20,302.5 мянган төгрөгийг ерөнхий журналд цалингийн өглөгийг өсгөж, НД-н сангаас авах авлагаар тусгасан боловч, Мөнгөн гүйлгээний тайланд орлого, зарцуулалтаар бүртгэж тайлагнаагүй байна.

Шийдэл:

Санхүүгийн тайланд залруулга хийлгэв.

Материаллаг бус дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

2. Төслийн ажилчдын цалин 13,124.0 мянган төгрөг, Багшийн цалин 1,240.2 мянган төгрөг, нийт 14,364.2 мянган төгрөгийн цалингаас НДШ ногдуулаагүй байна.

Шийдэл:

НДШ ногдуулаагүй нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 16.1. “Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн болон ажил олгогчийн тухайн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын төрөл бүрээр энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр сар бүр тооцож, тухайн сард нь багтаан нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлнэ.” заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Нийгмийн даатгалын тухай хуулийн 16.1.дах, “Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөх.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад 2015 онд Төслийн ажилчдын цалин 13,124.0 мянган төгрөг, Багшийн цалин 1,240.2 мянган төгрөг, нийт 14,364.2 мянган төгрөгийн цалингаас тухайн байгууллагын төлөх НДШ 3,160.1 мянган төгрөгийн алдааг залруулаагүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2015 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн төсвийн 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 23,462.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төвийн төсвийн 2015 оны санхүүгийн тайланд Ди Эй Би Жи Аудитын газраас хийсэн аудитаар 3 зөвлөмж өгсөн бөгөөд эдгээр зөвлөмжийн 100 хувь хэрэгжүүлж, ажилласан байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн төсвийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 4 хуудас, менежментийн захидал 2 хуудас, аудитын гэрчилгээ 1 хуудас, төсвийн гүйцэтгэлийн тайлан 1 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



С.МӨНХБАЯР

Н.МӨНХЗАЯА

А.ОДОНТУНГАЛАГ

Менежментийн захидал

Манай Аудитын компани Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 дах заалт, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Монгол улсын Ерөнхий аудиторын 2013 оны 158 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд аудит хийх чиг үүргээ аудитын бусад байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгэх журам"-ын 2.7-д заасны дагуу танай байгууллагын 2015 оны санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бид аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг танай байгууллагын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү Менежментийн захидлын агуулга нь Аудитын олон улсын стандартад тулгуурлан бидний гүйцэтгэсэн аудитын горим, ажлын үр дүнгээс үүдэн гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.


Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Аудитын байгууллагын энэхүү зөвлөмж та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад шаардлагатай баримт материалыг цаг хугацаандаа гаргаж өгч, биднийг мэдээллээр хангаж байсныг сайшаан тэмдэглэж байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан танай байгууллагын удирдлага болон ажилтнуудад талархал илэрхийлье.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



С.МӨНХБАЯР

**Асуудал 1: Цалин, НДШ, ХХОАТ
ногдуулалтын талаар**

Тэргүүлэх ач холбогдол №1

Аудитын ажиглалт

1. Төслийн ажилчдын цалин 13,124.0 мянган төгрөг, Багшийн цалин 1,240.2 мянган төгрөг, нийт 14,364.2 мянган төгрөгийн цалингаас НДШ ногдуулаагүй байна.

Эрсдэлүүд

1. Хууль, журам хэрэгжихгүй байх,
2. Нийгмийн даатгалын байгууллагын хянан шалгалтаар зөрчил болон төлбөр тавигдах.

Аудитын зөвлөмж

1. Нийгмийн даатгалын тухай хуулийн 16. 1. "Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Үйлчлүүлэгчийн хариу

1. Санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлэн ажиллана.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Зоонозын өвчин судлалын үндэсний төв

2015.12.31

төгрөгөөр

Код	Үзүүлэлт		Аудитласан	
			Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	3	-	-
8	АВЛАГА	4	-	-
11	УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР			
14	БАРАА МАТЕРИАЛ	5	400,026,937.93	653,286,744.97
15	Түүхий эд материал		340,429,223.02	583,678,577.39
16	Дуусаагүй үйлдвэрлэл			
17	Бэлэн бүтээгдэхүүн			
18	Хангамжийн материал		57,235,133.15	66,752,785.82
19	Мал, амьтад			
20	Бусад		2,362,581.76	2,855,381.76
21	НӨӨЦИЙН БАРАА			
22	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		400,026,937.93	653,286,744.97
23	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ			
24	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6		
25	Биет хөрөнгө		2,436,620,431.13	2,425,638,460.89
26	Барилга байгууламж		2,963,041,558.00	2,967,005,167.00
27	Хуримтлагдсан элэгдэл		(1,638,967,789.31)	(1,715,885,464.01)
28	Авто тээврийн хэрэгсэл		240,587,058.00	280,537,058.00
29	Хуримтлагдсан элэгдэл		(174,458,321.03)	(193,603,097.75)
30	Машин, тоног төхөөрөмж		1,508,957,844.85	1,803,916,957.17
31	Хуримтлагдсан элэгдэл		(575,452,576.68)	(820,309,199.14)
32	Тавилга, эд хогшил		206,968,128.93	215,968,128.93
33	Хуримтлагдсан элэгдэл		(94,055,471.57)	(111,991,089.25)
40	Бусад үндсэн хөрөнгө		446,551.70	446,551.70
41	Хуримтлагдсан элэгдэл		(446,551.76)	(446,551.76)
42	Дуусаагүй барилга байгууламж			
43	Биет бус хөрөнгө		3,384,166.84	10,462,234.06
44	Программ хангамж		7,686,000.00	16,685,567.10
45	Хуримтлагдсан элэгдэл		(4,301,833.16)	(6,223,333.04)
46	Бусад			
47	Хуримтлагдсан элэгдэл			
48	БУСАД ХӨРӨНГӨ			
49	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		2,440,004,597.97	2,436,100,694.95
50	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		2,840,031,535.90	3,089,387,439.92
51	Богино хугацаат өр төлбөр			
52	Өглөг	7		
53	Ажиллагчидтай холбогдсон өглөг			
54	Бараа үйлчилгээний бусад өглөг			
55	Татаас, санхүүжилтийн өглөг			
56	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг			
62	БОГИНО ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨРИЙН ДҮН		-	-
63	Урт хугацаат зээл			
64	УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨРИЙН ДҮН	8		
65	НИЙТ ӨР, ТӨЛБӨРИЙН ДҮН			
66	Засгийн газрын хувь оролцоо		1,948,935,905.49	1,948,935,905.49
67	Хуримтлагдсан үр дүн		329,851,203.68	579,207,107.70
68	Өмнөх үеийн үр дүн		329,851,203.68	329,851,203.68
69	Тайлант үеийн үр дүн			249,355,904.02
70	Дахин үнэлгээний нэмэгдэл		561,244,426.73	561,244,426.73
71	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН		2,840,031,535.90	3,089,387,439.92
72	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН		2,840,031,535.90	3,089,387,439.92

Аудитласан:

Ахлах аудитор

Аудитор

Анхан шатанд хянасан: Аудитор

Н.Мөнхзаяа

А.Одонтунгалаг

С.Мөнхбаяр

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Зоонозын өвчин судлалын үндэсний төв

2015.12.31

төгрөгөөр

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	тодруулга	Өмнөх он	Тайлант он
	1	2	3	4
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	1		
	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,585,077,084.00	1,773,770,888.76
	Улсын төсвөөс		1,585,077,084.00	1,773,770,888.76
	Урсгал		1,513,541,200.00	1,642,885,860.00
	Нэмэлт санхүүжилтийн орлого		71,535,884.00	94,585,028.76
	Хөрөнгийн		747,915,765.20	
	ЭМЯ-ны ЗГ-ын нөөц сан			36,300,000.00
	Бусад тусгай зориулалтын сангаас			5,979,000.00
	Тусламжийн орлого			320,776,539.42
	Төсөвт байгууллагын ажил үйлчилгээний орлого		7,631,699.25	205,579,442.21
	Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого		7,631,699.25	17,375,793.21
	Үнэ төлбөргүй бараа материалын орлого			180,992,975.00
	Үнэ төлбөргүй бараа материал-Хандив тусламжаар			7,210,674.00
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ҮР ДҮН (1)		2,340,624,548.45	2,306,105,870.39
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	2		
	АЖИЛЛАГЧИДАЙ ХОЛБООТОЙ ЗАРДАЛ		1,102,489,276.36	1,203,087,489.76
	Цалин, хөлс ба нэмэгдэл урамшил		991,232,376.36	1,076,148,581.84
	Цалин		989,261,376.36	1,076,148,581.84
	Цалингийн тусгай нэмэгдлүүд		1,971,000.00	
	Нийгмийн хамгааллын шимтгэл		111,256,900.00	126,938,907.92
	Тэтгэвэр тэтгэмжийн шимтгэл		92,539,179.18	106,620,751.85
	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл		18,717,720.82	20,318,156.07
	Бараа үйлчилгээний урсгал зардал		788,740,019.80	843,820,085.48
	Тогтмол зардал		51,268,721.37	54,478,155.77
	Гэрэл цахилгааны зардал		18,375,359.20	24,859,461.77
	Түлш, халаалтын зардал		28,480,799.00	24,659,001.00
	Цэвэр, бохир усны зардал		4,412,563.17	4,959,693.00
	Үйл ажиллагааны зардал		239,882,644.07	213,942,202.85
	Хоол		1,200,000.00	8,500,000.00
	Эм		238,682,644.07	205,442,202.85
	Бусад бараа үйлчилгээн зардал		497,588,654.36	575,399,726.86
	Бичиг хэргийн материал		18,544,699.60	28,998,260.00
	Тээвэр, шатахууны зардал		42,720,874.78	41,745,157.33
	Шуудан холбооны зардал		4,496,539.64	3,532,746.32
	Дотоод томилолтын зардал		20,251,484.00	27,727,250.00
	Гадаад томилолтын зардал			
	Ном хэвлэлийн зардал		390,377.00	
	Зөөлөн эдлэл, нормын хувцас		3,729,413.00	1,169,846.00
	Төлбөр хураамж, жижиг татварууд		77,830.00	113,000.00
	Харуул хамгаалалтын зардал			
	Тээврийн хэрэгслийн даатгал		1,337,302.00	1,455,900.00
	Тээврийн хэрэгслийн татвар		617,000.00	686,600.00
	Мэдээллийн технологи		3,631,920.00	3,514,246.00
	Тээврийн хэрэгслийн оношлогоо		95,000.00	121,000.00
	Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр		2,000,000.00	
	Урсгал засварын зардал		8,906,506.00	21,343,758.63
	Газрын төлбөр		3,848,000.00	3,367,000.00
	Бусад төвлөрсөн арга хэмжээ		8,054,000.00	
	Бусад зардал		32,371,468.92	784,500.00
	Байрны түрээсийн зардал			800,000.00
	Тэтгэвэрт гарагсдад олгох нэг удаагийн дэмжлэг		28,411,200.00	30,208,000.00
	Хог хаягдал устгах зардал		9,761,510.00	11,046,559.00
	Төвлөхүүлэх шилжүүлэг		7,993,525.07	36,637,922.14
	Нэг удаагийн буцалтгүй тусламж			1,371,790.00
	Элэгдлийн зардал		300,350,004.35	360,776,191.44
	Хөтөлбөр арга хэмжээний зардал		-	9,842,391.13
	НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЗАРДАЛ		18,355,000.00	9,842,391.13
	Нэг удаагийн тэтгэмж		18,355,000.00	9,842,391.13
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		1,891,229,296.16	2,056,749,966.37
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН		449,395,252.29	249,355,904.02
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРЛАГЫН ДҮН (5)		-	-
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН		449,395,252.29	249,355,904.02

Аудитласан:

Ахлах аудитор

Аудитор

Анхан шатанд хянасан:Аудитор

Н.Мөнхзаяа

А.Одонтунгалаг

С.Мөнхбаяр

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Зоонозын өвчин судлалын үндэсний төв

2015.12.31

төгрөгөөр

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	тодруулга	Өмнөх он	Тайлант он
	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,585,077,084.00	1,794,073,453.76
	Улсын төсвөөс		1,585,077,084.00	1,737,470,888.76
	Урсгал		1,513,541,200.00	1,642,885,860.00
	Нэмэлт санхүүжилтийн орлого		71,535,884.00	94,585,028.76
	Нийгмийн даатгалын сангаас			20,302,565.00
	ЗГ-ын нөөц сангаас			36,300,000.00
	Бараа үйлчилгээний орлого		7,631,699.25	17,375,793.21
	Өмчийн орлого			
	Төсөвт байгууллагын ажил үйлчилгээний орлого		7,631,699.25	17,375,793.21
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1.00	1,592,708,783.25	1,811,449,246.97
	АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБООТОЙ ЗАРДАЛ		1,106,638,925.94	1,203,087,489.76
	Цалин, хөлс ба нэмэгдэл урамшил		995,382,025.94	1,076,148,581.84
	Цалин		851,972,625.94	933,412,981.84
	Цалингийн тусгай нэмэгдлүүд		143,409,400.00	142,735,600.00
	Нийгмийн хамгааллын шимтгэл		111,256,900.00	126,938,907.92
	Тэтгэвэр тэтгэмжийн шимтгэл		111,256,900.00	126,938,907.92
	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл			
	Бараа үйлчилгээний урсгал зардал		424,009,759.08	540,786,436.08
	Тогтмол зардал		51,268,721.37	58,441,764.77
	Гэрэл цахилгааны зардал		18,375,359.20	24,859,461.77
	Түлш, халаалтын зардал		28,480,799.00	28,622,610.00
	Цэвэр, бохир усны зардал		4,412,563.17	4,959,693.00
	Үйл ажиллагааны зардал		249,875,947.00	275,728,992.22
	Хоол		1,200,000.00	8,500,000.00
	Эм		248,675,947.00	267,228,992.22
	Бусад бараа үйлчилгээн зардал		122,865,090.71	206,615,679.09
	Бичиг хэргийн материал		14,108,140.00	27,028,400.00
	Тээвэр, шатахууны зардал		44,954,212.00	44,417,894.00
	Шуудан холбооны зардал		4,496,539.64	3,532,746.32
	Дотоод томилолтын зардал		20,251,484.00	27,727,250.00
	Гадаад томилолтын зардал			
	Ном хэвлэлийн зардал		616,000.00	492,800.00
	Зөөлөн эдлэл, нормын хувцас		4,500,000.00	5,315,000.00
	Төлбөр хураамж, жижиг татварууд		4,880,000.00	4,870,000.00
	Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр		2,000,000.00	415,000.00
	Банкны үйлчилгээний хураамж		77,830.00	113,000.00
	Мэдээллийн технологийн зардал		3,631,920.00	3,099,246.00
	Урсгал засварын зардал		6,846,900.00	22,976,758.63
	Төвлөрүүлэх шилжүүлэг		7,993,525.07	36,637,922.14
	Хог хаягдалын зардал		7,500,540.00	8,887,097.00
	байрны түрээсийн зардал		1,008,000.00	800,000.00
	Бусад зардал			20,302,565.00
	НИЙГМИЙН ХАМГААЛАЛЫН ЗАРДАЛ		46,766,200.00	41,422,181.13
	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал		18,355,000.00	1,371,790.00
	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгө		28,411,200.00	40,050,391.13
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		1,577,414,885.02	1,785,296,106.97
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		15,293,898.23	26,153,140.00
	Хөрөнгийн орлого			
	Биет ба биет бус хөрөнгө худалдаж авсан зардал		16,793,900.00	26,153,140.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН		16,793,900.00	26,153,140.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		(16,793,900.00)	(26,153,140.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН (IX)=(VII)+(VIII)		(1,500,001.77)	(0.00)
	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,500,001.77	-
	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-	-

Аудитласан:

Ахлах аудитор

Аудитор

Анхан шатанд хянасан:Аудитор

Н.Мөнхзаяа

А.Одонтунгааг

С.Мөнхбаяр

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Зоонозын өвчин судлалын үндэсний төв

2015.12.31

төгрөгөөр

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан	Дахин үнэлгээний	Хуримтлагдсан	Засгийн газрын нийт оролцооны түвшин
2013оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,948,935,905.49	563,460,961.12	(103,405,583.00)	2,408,991,283.61
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			2,216,534.39	2,216,534.39
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-			-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт		(2,216,534.39)		(2,216,534.39)
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз				-
Тайлант үеийн үр дүн			431,040,252.29	431,040,252.29
2014 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,948,935,905.49	561,244,426.73	329,851,203.68	2,840,031,535.90
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,948,935,905.49	561,244,426.73	329,851,203.68	2,840,031,535.90
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт		-		-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз				-
Тайлант үеийн үр дүн			249,355,904.02	249,355,904.02
				-
2015 оны 12-р сарын 31-аарх үлдэгдэл	1,948,935,905.49	561,244,426.73	579,207,107.70	3,089,387,439.92

Аудитласан

Ахлах аудитор

Аудитор

Анхан шатанд хянасан:



Н.Мөнхзаяа



А.Одонтунгалаг

С.Мөнхбаяр

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
II. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,656,573,600.00	1,623,623,731.07		
А. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,656,573,600.00	1,623,623,731.07	32,949,868.93	98.01
1. Бараа, үйлчилгээний зардал	1,656,573,600.00	1,623,623,731.07	32,949,868.93	98.01
1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,081,394,200.00	1,063,024,581.84	18,369,618.16	98.30
Үндсэн цалин	938,658,600.00	920,288,981.84	18,369,618.16	98.04
Нэмэгдэл, урамшил	82,735,600.00	82,735,600.00	-	
Унаа, хоолны хөнгөлөлт	60,000,000.00	60,000,000.00	-	100.00
1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	129,880,900.00	126,938,907.92	2,941,992.08	97.73
Тэтгэвэрийн даатгал	129,880,900.00	126,938,907.92	2,941,992.08	97.73
1.3 Бараа үйлчилгээний бусад зардал	445,298,500.00	433,660,241.31	11,638,258.69	97.39
Бичиг хэргийн зардал	2,690,900.00	5,524,900.00	(2,834,000.00)	205.32
Гэрэл цахилгаан	20,017,100.00	24,859,461.77	(4,842,361.77)	124.19
Түлш, халаалт	36,102,000.00	28,622,610.00	7,479,390.00	79.28
Тээвэр (шатахуун)	40,480,200.00	37,364,174.00	3,116,026.00	92.30
Шуудан, холбоо	4,057,300.00	3,532,746.32	524,553.68	87.07
Цэвэр, бохир ус	5,271,400.00	4,959,693.00	311,707.00	94.09
Хоол			-	
Эм	233,098,100.00	230,818,992.22	2,279,107.78	99.02
Ном хэвлэлийн зардал	492,800.00	492,800.00	-	100.00
Түрээсийн зардал			-	
Дотоод албан томилолт	7,934,900.00	5,247,250.00	2,687,650.00	66.13
Газрын төлбөр	3,848,000.00	3,367,000.00	481,000.00	87.50
Тээврийн хэрэгслийн татвар	720,000.00	720,000.00	-	100.00
Тээврийн хэрэгслийн даатгал	630,000.00	630,000.00	-	100.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	153,000.00	153,000.00	-	100.00
Жижиг эд хогшил худалдан авах	12,427,000.00	11,399,890.00	1,027,110.00	91.73
Хог хаягдал бусад	8,909,100.00	8,887,097.00	22,003.00	99.75
Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,315,000.00	5,315,000.00	-	100.00
Банк санхүүгийн байгууллагын төлбөр	150,400.00	113,000.00	37,400.00	75.13
Урсгал засварын зардал	20,075,000.00	21,098,591.00	(1,023,591.00)	105.10
Төвлөрүүлэх шилжүүлэг			-	
Төрийн нэрийн өмнөөс гүйцэтгэсэн ажил	415,000.00	415,000.00	-	100.00
Мэдээлэл сурталчилгааны зардал	4,358,900.00	3,099,246.00	1,259,654.00	71.10
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	1,959,400.00	1,371,790.00	587,610.00	70.01
Нэг удаагийн буцалтгүй дэмжлэг	36,193,000.00	35,668,000.00	525,000.00	98.55
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ			-	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,656,573,600.00	1,623,623,731.07	32,949,868.93	98.01
Үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,000,000.00	17,375,793.21	(13,375,793.21)	434.39
Төсвөөс санхүүжүүлэх	1,652,573,600.00	1,606,247,937.86	46,325,662.14	97.20
Нэмэлт санхүүжилт			-	
ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгө			-	
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл			-	
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл			-	
III. БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	
Төсвийн байгууллага			-	
АЖИЛЛАГСАД БҮГД		130.00		

Аудитласан :

Аудитор

Аудитор

Анхан шатанд хянасан : Аудитор

А.Одонтулгалаг

Н.Мөнхзаяа

С.Мөнхбаяр